

まんがでわかる



Монгол хэл


モンゴル語版

# 航空業の安全衛生


Комикоор танилцах

Агаарын тээврийн аюулгүй байдал, эрүүл ахуй





Өнөөдөр агаарын тээврийн салбарын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сурцгаая.



Агаарын тээврийн ажил гэхээр маш сайхан дүр төрх буудаг шүү.




Тийм шүү.



Бодитоор ямархуу ажил байдаг юм бол оо?


Сонирхолтой санагдчихлаа.



Эхлээд хөдөлмөрийн осол үүсэх нөхцөл байдлын талаар авч үзэцгээе.

За, ойлголоо.

Хөдөлмөрийн ослын гол шалтгаанууд нь дараах байдалтай байна.



### Хөдөлмөрийн ослын тоо


1	Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй	99осол
2	Явганаас бэртэх	28осол
3	Зам тээврийн осол (зам)	24осол
4	Нурж унах, Өндрөөс унах	19осол
5	Мөргөлдсөн	17осол

Лавлах материал: Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх төв хороо "Хөдөлмөрийн ослын шинжилгээний мэдээлэл: Агаарын тээврийн салбарын дүн (2018) (2019 оны 8 сарын шинэчлэл)



"Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй" осол их юм аа.





Агаарын тээврийн салбар нь зорчигчдын үнэт амь настай шууд холбогддог ажил юм. Дүрмээ баримталснаар, өөрийнхөө ч, зорчигчдын ч амь нас, эрүүл мэндийг хамгаалж чадна.



Тэр амь насыг бүх хүчээрээ хамгаалахын тулд, эхлээд өөрөө эрүүл чийрэг байх ёстой гэж бодохгүй байна уу?

Хүнд бэртэл аваад ажиллаж чадахааргүй болвол гэр бүлийнхэн ч санаа зовж, орлогын тал дээр ч хэцүүдэнэ биз дээ.



Тийм ч учраас дүрмээ баримтлах нь хамгийн чухал юм.

Эргэн тойрноо сайтар ажиглаж, тогтсон дүрмийн дагуу зөв ажиллах.



Шаардлагатай тоноглол болон хамгаалалтын багаж хэрэгслийг ч ажилд гарахын өмнө сайтар шалгаарай.

Өөр ямар жишээ байна вэ?



Онгоцон дотор цэвэрлэгээний үеэр суудлын ширээнд гараа хавчуулах,

Ажил эхлэхээс өмнө онгоц руу орох шатнаас хальтарч унасан гэх мэт тохиолдлууд байдаг.



Аанха...

За тэгэхээр,



Ммм...?





Бодит ажлын талбарыг,

харцгаая.



1

# Жишээ 1



Чи амрахгүй юм уу?

Хурдхан янзлаад дуусгамаар байна аа.

Эвтэйхэн амсхийхээр болтлоо зогсолтгүй хийнээ.






Фүү,  
Нилээд хэцүү болж байна шүү.



Ашгүй нэг юм сүүлийн ачаа харагдаж байна.



Дахиад жоохон л тэсчихвэл..





Түс..



Шинэ  
ажилтан!

Хөөе, шинэ  
ажилтан!  
Зүгээр үү!?



Эмчийн өрөө

Хөнгөн хэлбэрийн  
наранд цохиулалт  
гэнэ.

Юутай ч үдээс хойш  
амар даа.


Хүнд өвдчихөөгүй нь  
яамай даа. Наранд  
цохиулахаас урьдчилан  
сэргийлэхийн тулд.

Ойр ойрхон шингэн  
юм ууж, давс хэрэглэх.




Давстай чихэр

Сэрүүхэн газар амрах.



Өөрийн, бусад ажилчдын  
биеийн байдал нэг л биш  
байна гэж бодвол шууд  
мэдээллэх.



Хангалттай унтаж  
амрах, согтууруулах  
ундаа хэтрүүлэн  
хэрэглэхээс зайлсхийх.  
Ойлгосон уу?







Тиймээ, цаашид  
анхааръя.





Наранд цохиулах талаар дэлгэрэнгүй  
мэдээлэл авахыг хүсвэл, бүх салбарын  
танилцуулгасан-комик үзээрэй.

# Жишээ 2







Тийм бий. Сандраад мөргөчихсөн байх нь.

Ямар нэг хэвийн бус байдал ажиглаад, удирдагчид мэдэгдье гэсэн чинь зөв. Халдварт өвчин ч байх юм бил үү.

Уучлаарай.



Онгоцон дотор, цэвэрлэгээний багаас гадна өөр ажилчид ч бас ажиллаж байгаа.


Эргэн тойрноо сайтар ажиглаж, нөхцөл байдлыг ойлгох хэрэгтэй.

OK!

Зөрлөө шүү!

Жаахан л анхаарал суларснаас ажилчид хоорондоо мөргөлдөж болзошгүй.

NG!




Мөн суудлын халаасанд хурц үзүүртэй зүйл байх эрсдэлтэй учраас сайн шалгана.


Эмчид үзүүлчихээд ир.

За

Үүний дараа эмчийн өрөөнд эмнэлгийн тусламж аваад, алдаагаа эргэцүүлэн бодсон юм.



# Жишээ 3






За, ажлаа эхлүүлье.



Дээд хэсгийн бохирдлын байдал сайн харагдахгүй байна аа.



Шалны модоо дахиад жоохон дээш нь хүргэчихвэл..



Хөөе! Хамгаалалтын шил зүүх дүрэмтэй шүү.

Нүдэнд угаалгын бодис орж магадгүй учраас!


Үгүй ээ, гэхдээ бохирдол нь...



Нилээд бохирдсон байна шүү.

Аанхан, сайн арчихгүй бол.

Гэхдээ...



Вааа!!

Под под

Под



Зүгээр үү!?


Угаалгын бодис нүдэнд орчихлоо.



Ямар ч байсан нүдээ угаачихаад ир!

Удирдагчид би мэдээлчихье.

Аанхан.



Сархх...



Нүд жоохон эвгүй хэвээрээ л байна даа.



Дуулсан шүү.



Угаалгын бодис нүдэнд орвол үрэвсэл үүсгэх болон нүдний эвэрлэг бүрхэвчийг гэмтээх тохиолдол ч байдаг.

Маш болгоомжтой байх хэрэгтэй.



Бас дээр нь хамгаалалтын нүдний шил зүүж нүдээ хамгаална!



Зөвхөн хамгаалалтын шил ч биш, бээлий, бүрэн бэхэлгээ хэрэглэхээ ч мартаж болохгүй.

Тогтсон ажлын дүрмийг баримтлах



Эхлээд эмчийн өрөө рүү яваарай.


За, уучлаарай.

Мэргэжлийн эмчид үзүүлж зөвлөгөө авсан болохоор аз болоход хүндэрсэнгүй өнгөрчээ.





Аюул нь санаанд оромгүй ойрхон байдаг гэдгийг сайн ойлгосон байх аа?



Эдгээр дүрийн тэнэг үйлдлүүд нь хэн нэгэнтэй адилхан байна шүү.

Мм? Ямар нэгэн юм хэлсэн үү?




Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад хүн нэг бүрийн ухамсар төдийгүй дүрмээ баримтлах маш чухал үүрэгтэй.

Тэгээд...



Хөдөлмөрийн осол гэдэг нь чамайг тойрч гардаг бусдын хэрэг огт биш.

Дүрэм журам баримтлах нь "Өөрийн биеээ", "Гэр бүлээ", "Амьдралаа" хамгаалж байгаа хэрэг гэдгийг сайн ойлгож аваарай.



Түүнчлэн ямар нэг зүйл тохиолдоход

Ажлын хамт олонтойгоо өдөр тутамдаа холбоо харилцаатай байх нь чухал юм.



За!

Хөдөлмөрийн ослоос болгоомжлон өдөр бүр хичээнэ ээ.

Аанхан


Дүрэм баримтлахыг нийтэд нэвтрүүлб.

## Агаарын тээврийн салбарт анхаарах зүйлс


(Гадаа талбайн ажил)





**1** | Замын хөдөлгөөний дүрэм баримталцгаая.



**2** | Аюултай газар луу орохыг хориглоно.



**3** | Цаг агаар (Хүчтэй салхи, аянга цахилгаан)-аас болгоомжил.



**4** | Наранд цохиулахаас сэргийл.




## Агаарын тээврийн салбарт анхаарах зүйлс


(Тасалгаан дахь ажил)



**5** | Мөргөлдөхөөс болгоомжил



**6** | Заавар бичиггүй онгоцны аливаа тоног төхөөрөмжид хүрэхгүй.



**7** | Хавчуулагдахаас болгоомжил





Комикоор танилцах

## Агаарын тээврийн аюулгүй байдал, эрүүл ахуй

2020 оны 3 сарын хэвлэл

Эрхлэн гаргасан: Эрүүл мэнд, хөдөлмөр,  
нийгмийн хамгааллын яам

Төлөвлөсөн: Mizuho Information & Research Institute, Inc.

Хянан тохиолдуулсан: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
сургалтын материал бэлтгэх комисс  
Агаарын тээврийн салбарт хамаарах аюулгүй ажиллагааны  
сургалтын материал бэлтгэх ажил

Боловсруулсан: Sideranch Inc.

Тус материалын талаарх лавлагаа

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны  
Хөдөлмөрийн стандартын хороо, Аюулгүй байдал, эрүүл  
ахуйн газар, Аюулгүй байдлын хэлтэс